



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 07 сарын 09 өдөр

Дугаар 4/62

Мандалговь

Эрсдэлд нөхцөлд байгаа хүүхдүүдийг
даатгалд хамруулах тухай

Хүүхдийн хамгааллын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2.8 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрсдэлд нөхцөлд амьдарч байгаа хүүхдүүдийг гэнэтийн ослын эрсдэл болон бүх төрлийн хүчирхийллийн эрсдлийг багтаасан даатгалын цогц үйлчилгээнд хамруулсугай.

2. Даатгалын үйл ажиллагаанд шаардагдах 4.160,000 (Дөрвөн сая нэг зуун жаран мянга) төгрөгийг Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрөөс санхүүжүүлэхийг нягтлан бодогч (С.Чинбат)-д зөвшөөрсүгэй.

3. Хүүхдүүдийг даатгалд хамруулах ажлыг 2021 оны 07 дугаар сарын 19-ний өдрөөс 08 дугаар сарын 20-ны өдрүүдэд зохион байгуулж, үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2021 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Даргын дэргэдэх зөвлөлд танилцуулахыг Хүүхэд хамгааллын мэргэжилтэн (Б.Цэцэгт)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ГАНЗОРИГ

4311901 3